

МОНГОЛЫН НҮҮДЭЛЧДИЙН УРАН ЗОХИОЛ ДАХЬ ААВЫН ДҮР БУЮУ ХҮН БАЙХЫН УЧИР

Д. Өрнөхдэлгэр

Ph.D, дэд профессор.

Ховд их сургууль, Ховд, Монгол Улс

E-mail: өрнөхдэлгэр@gmail.com

Товч хураангуй

Монголын аман болон бичгийн уран зохиолд ээж, аавынхаа тухай бичээгүй, дуулаагүй зохиолч олдохгүй л болов уу. Монголын эртний болон орчин үеийн аль ч уран зохиолд эцэг эхийн үүрэг, зан чанар олон хэлбэр, өнгөөр илэрч ирсэн байдаг. Эцэг эхчүүд бол хүүхдүүдийнхээ аз жаргал, сайн сайхны төлөө зүүж, урладаг хүмүүс. Аав гэдэг үгийг монгол хэлэнд хэрэглэвэл толгойд орж ирсэн эхний үгс нь ээж. Дараа нь эх орон, хүү, уул, бурхан гэх мэт бөгөөд энэ бүхэн нь хүний амьдралын утга учир, мөн чанарыг тодруулж өгдөг. Монголын орчин үеийн уран зохиолд аавын тухай олон мянган бүтээл бий. Энэ сэдвээр 60 гаруй зохиолч, яруу найрагчдын 100 орчим бүтээлд дүн шинжилгээ хийхэд аавын дүр төрх, нас, сэтгэл санаа, зан чанар, өрөвч сэтгэл, үр хүүхдийнхээ төлөөх гавьяа, чин сэтгэл гэх мэт олон ялгааг харж болно. Монголын орчин үеийн уран зохиолд эцгийн үүргийг илэрхийлэхдээ дараах зургаан ерөнхий шинж чанарыг товойлгон үзүүлсэн байна: 1) эцэг хүний ач хариулах арга хэмжээ авах гэсэн хүүхдийн дотоод хүсэл; 2) эцгийн ариун дүр төрх, нандин дурсамжийг хадгалах; 3) хайртай эцэг эхээсээ хол байгаа хүүхдүүдийн чин сэтгэлийн талархал; 4) эцгээ алдсандаа уй гашуугийн илэрхийлэл; 5) эцэг хүний хайр, сүсэг бишрэлийг харуулах баяр баясгалан; 6) хортой хүчнээс хамгаалах эцэг хүний ариун дүр.

Түлхүүр үг

Монголын нүүдэлчид, уран зохиол, эцэг.

UDC 177

THE IMAGE OF THE FATHER IN MONGOLIAN NOMADIC LITERATURE OR WHY IT IS NECESSARY TO BE A MAN

D. Urnukhdelger

Ph.D, Associate Professor.

Hovd University, Hovd, Mongolia

E-mail: ornokhdalgarp@gmail.com

Annotation

In Mongolian oral and written literature, you will not find a writer who has not written or spoken about his mother and father. In both ancient and modern Mongolian literature, parental roles and attributes have come to be seen in many forms and colors. Parents are the ones who wear them for the happiness and well-being of their children. When the word «father» is used in Mongolian language, the first words that come to mind with it are «mother», then «homeland», «son», «mountain», «god», etc., all of which highlight the meaning and essence of human life. Modern Mongolian literature contains thousands of works about the father. Analyzing about 60 works of more than 100 writers and poets on this topic, we can see many differences in the image of the father, age, mood, character, compassion, merit for his children, sincerity, etc. When expressing the role of a father in contemporary Mongolian literature, it has been embossed with the following six general characteristics: 1) the child's inner desire to repay and respond to his or her father's beneficence; 2) the sacred image of father and a precious memory left or kept in a moment; 3) cordial confession by children for their parents from a far place; 4) the expression of grief over the loss of a loving father; 5) the joy of rejoicing in the love and filial piety by father; 6) the expression of protecting or taking sides of father from any evil force.

Keywords

Mongolian nomads, literature, fatherhood

О Р Ш И Л

Цаг хугацааны адбиш зангийн эрхээр хүмүүний санааны жолоо цулбуур эвхэгдэн хурд явдал саарах хэдий ч борви тойг тэнийлгэж, бохир сүүдрээс хамгаалан, хөлийг дөрөөнд, гарыг ганзаганд хүргэсэн ижий, аавын гэгээн дүр, үйл хэрэг, өгүүлэн өгүүлсэн ачлалт сургаал зүрхний угт улам бүр гэрэлтэж, эрхшээн болгоосон амьдралын явдал мөрөөс алгасран холдох аваас урьдын ерөөлөөсөө хазайн, мунхаг муугийн харанхуйд төөрөлдөх сэтгэлийн чилүүрийг эдлэх хувьтай. Тиймийн учир зүрхний угт тодорсон гэгээн гэрлээ зохиолч, яруу найрагчид үгийн сайханд урвуулан буулгасаар мянга мянган жил улирчээ.

«Цаст Хималайн өндөр уулсыг давж, Монголын тал руу урссан соёлын олон мянган алтан шижим» (Ц. Дамдинсүрэн)-ээс өмнө энэ тал нутагт оршин байсан байгаль дэлхийгээ ахуй чигээр нь өвлүүлсэн эцэг өвгөдийн холч ухаан, хүн хүнээ тэгш хүндэтгэн үзсэн энэрэлт сэтгэл, үдлээд л буцах хорвоод амар түвшин аж төрөхийн тэнүүн хүслэн, нүцгэн ирээд явахын зуурт үл сэвтэх учиртай хожим хойдын зам мөр тод зурайн байсан гэдэгт итгэнэм.

Монголчуудын оюун соёлын хамгийн амин сүнс нь унаган хэл, сэтгэлгээгээр туурвин бүтээсэн үгийн урлан бөгөөд ээж, аавын элбэрэл хайр, энхрий жаахан үрсийн гэрэл цацраасан инээд, юунд ч санаа зоволгүй явтал жирэлзэн өнгөрдөг залуу насны ааг омог гээд хүмүүний ариун нандин бүхнийг агуулсан сэтгэлийн хөдлөл, уянга мэдрэмжийн гүнээс урган гарсан талстууд урлаг, утга зохиолын мөнхийн сэдэв, үнэт зүйл болсоор ирсэн билээ.

Манай уран зохиолын түүхнээ хурдан бичих, олон ном зохиол гаргаснаараа уралдахаас гадна хэний ч бичээгүй «сэдэв хөндөх» (малчин, жолооч, эмч, цэрэг, хилчин, тууварчин... гээд бүр сүүлдээ Гандангийн тагтааг ч бичсэн), эсвэл хэн ч дүрслээгүй уран сайхны дүр, дүрслэл (туулайн гүйдэл шиг салхи, суусрын гүйдэл шиг салхи, пансан салхи, ягаан салхи гэх мэт) бүтээх гэх мэтээр өрсөлдсөн он жилүүд туурвил зүйн чамгүй туршлагыг бидэнд үлдээсэн ч мөнхийн сэдэв болох хайр сэтгэл, эцэг эхийн элбэрлийн уянгыг тойрсон эгшиг дуу улам гойд, дахин давтагдашгүй түг түмэн өнгөөр дуурсаар байна.

Гэлээ гээд, энэ бүх сэдэв, дүр дүрслэлийн цаана жинхэнэ хүнийг харуулсан, чин үнэн уран сайхныг уншигчдад нээн үзүүлсэн, сэтгэл зүрхийг шимшрүүлсэн нь аав, ээжийн дүр мөнөөс мөн. Энэ тухайд, академич Х. Сампилдэндэв, «Сэтгэлийн уянгын мөнхийн сэдвийн нэг нь эцэг эхийн элбэрэл хайр юм. Хүүхэд бүр хэлд орох үедээ хэлж сурсан цөөн хэдэн үгэнд «ээж», «аав» гэсэн үгс голлодог шиг яруу найрагч болгоны эн түрүүн бичих дуртай сэдвийн нэг нь эцэг эхийн ач билээ» (Сампилдэндэв, 1990: 150) хэмээгээд яруу найрагчдын эхийн элбэрэл хайрын ачийг магтан дуулсан бүтээлүүдийг авч үзэж манай яруу найрагчид эцэг эхийн дүрийг бүтээхдээ уянгын тодорхой дүрийг бүтээж, дүрийн сэтгэл хөдлөл, догдлолыг нээж гаргаж чадсан нь сэтгэлийн ай саваас амьдралын тодорхой дүрслэлд шилжин хүний сэтгэхүйг уянгалаг аясаар нээн харуулах болсон урлах аргын нэгэн шат болж байгааг нэгтгэн дүгнэсэн нь бий. Тэгвэл профессор Д. Цэнд, «Утга уянгын яруу найргийн эцэг эхийн ачлал элбэрлийг магтан дуулсан яруу найраг 1940-өөд оноос эхлээд ихээхэн

хөгжилтийг олсон явдал нь хүний сайхан сэтгэл, сайн сэтгэлийн үзүүрт ямагт дурсамж, дурдатгал, аз жаргалд тэмүүлсэн сэтгэлийн хөг аялгуу ямагт шингэж байдагтай холбоотой» (Цэнд, 1972: 214)-г онцлон дуртгажээ.

ХЭРЭГЛЭГДЭХҮҮН, АРГА

Монголын аман ба бичгийн зохиолд эх, эцгийн тухай бичээгүй, дуулаагүй уран бүтээлчийг олъё гэвэл үгүй биз. Монголын эрт эдүгээгийн аль ч уран зохиолд эцэг эхийн дүр олон янзын өнгө төрхтэйгээр оршсоор иржээ. Эцэг эх бол цаг ямагт үрийнхээ төлөө явсаар өөрсдөө элэгддэг нэгэн. Монгол хэлэнд «аав» гэсэн үгийг хэлэхэд түүнтэй хоршин хамгийн түрүүнд толгойд орж ирдэг үг нь «ээж», тэгээд «нутаг», «хүү», «уул», «бурхан» бөгөөд энэ бүхэн нийлээд хүмүүний амьдралын утга учир, амин хэлхээг тодруулж өгдөг.

Сэтгэц-хэл шинжээчдийн үзэж байгаагаар бол тухайн хүний үгийн нөөц буюу лексиконьг бүрдүүлж буй үг тус бүрийг хадгалж, хянаж байдаг нейронууд буюу логогенүүд нь хүн уг үгийг сонсох болон унших үед идэвхжиж нейроны аварга сүлжээнд орж, бусад үгсийг идэвхжүүлж, ингэснээр тухайн үгийг болон хэлсэн бичсэнийг ойлгох явдлыг ханган өгч байдаг (Scovel, 2000). Үгс нь логогенд тус тусдаа болон харилцан шүтэлцээнд хадгалагдаж байдаг ба үгийг хэрэглэх үед тухайн үгтэй хамгийн их холбоотой үг зохиогч, уншигчийн санаанд хамгийн түрүүнд орж ирдэг байна. Энэ үгийн дараа энэ үгийг хэлье гэж бодоод хэлбэл яруу найргийн мөн чанараас холддог тул шууд харван орж ирсэн үгэнд л эрчимлэг чанар хадгалагдаж байдаг. Монголын орчин үеийн яруу найргийн бүтээлүүдээс харахад, «аав» гэсэн өдөөгч үгийн хамгийн давтамжтай анхдагч үг нь «ээж» (шүлэг зохиолд «аав ээж хоёр» гэж их хоршиж орсон нь угсаатны сэтгэц хэл шинжлэлийн онцгой үзэгдэл болно) гэж гарч байна. Тэгвэл, монголын орчин үеийн яруу найрагч аавын дүрийг тодотгон дүрслэхдээ,

- ⇒ Тэнгэр адил саруул ухаантай аав
- ⇒ Уужим бодолтой аав
- ⇒ Хангай шиг түшигтэй аав минь
- ⇒ Эрдэнэ шиг сургаалтай аав
- ⇒ Саруул сайхан туяа цацраагч аав минь
- ⇒ Далай их уужим шинжтэй аав минь
- ⇒ Буянтай буурал аав минь
- ⇒ Нуруутай амьдарсан аав аа
- ⇒ Холч ухаан, алсын бодолтой аав аа
- ⇒ Хан буурал эцэг минь
- ⇒ Уул шиг түшигтэй аав минь
- ⇒ Тэнгэр аав минь
- ⇒ Тээврийн тэрэгний жолооч аав минь
- ⇒ Хээгүй гүдэсхэн аав минь
- ⇒ Энгэртээ мэшидэг аав минь
- ⇒ Дунхгэр буурал аав
- ⇒ Уул шиг амгалан аав
- ⇒ Гүрмэл бугуйл шиг аав

- ⇒ *Хөрслөг аав минь*
- ⇒ *Настай буурал аав минь*
- ⇒ *Гандуу дээлтэй аав минь*
- ⇒ *Тэнүүн буурал аав*
- ⇒ *Хаан буурал аав*
- ⇒ *Олонтой явсан аав минь*
- ⇒ *Дэндүү олонтой аав минь*
- ⇒ *Угаас гүндүүгүй аав*
- ⇒ *Атгасан гарт нь хайр шингэсэн аав минь*
- ⇒ *Аав мод*
- ⇒ *Аав уул*
- ⇒ *Дууны тэнгэр аав минь*
- ⇒ *Дэлхийг дэрлэсэн аав минь*
- ⇒ *Гучин наймтай аав минь*

гэх үгсийг хэрэглэсэн байх агаад эдгээр үг хэллэгийн ерөнхий утга санаа нь эцэг хүний нөмөр нөөлөг, холч ухаан бодол, үнэт сургаал, үр хүүхдээ гэсэн сэтгэлтэй холбогдон уужим, уудам, дэлгэр, тэнүүн, тэнгэр, далай мэт гэхчлэн энгүй их гэсэн утгад төвлөж байгаа нь үндэсний менталитет сэтгэлгээний онцлог юм. Тэшиж одсон он жилүүд тэрлэгтэй аавын минь магнайд нь зурвас үлдээн, тэнэгхэн үрсийг нь унших болов уу гэж хардаг биз... Тиймийн учир,

Аав минь хоймроо эзлэхээрээ

Аяга барих ч журамтай болдогсон

Хорол тоонын чагтага газардалгүй

Хот айлынхан цэгцхэн нүүдэгсэн (До. Цэнджав) гэж аргалын нурам дотроо халуун шиг амин хайраа цээжиндээ хадгалдаг аавын ухаан, хайрын дүрийг урлажээ.

Мөн чанар хийгээд аавын дүр

Хүний мөн чанарын тухай ярилцахад хамгийн түрүүн сэтгэл ухамсрын тухай асуудал хөндөгдөн гарч ирдэг. Хүмүүний мөнхөд өөрчлөгдөшгүй чанарууд нь ямагт бусдаас үл хамаарах оюун сэтгэлгээний эрх чөлөөт байдлыг эрхэмлэн, түүнийхээ төлөө тэмцэж байдагт оршино. Тэрхүү байдлыг ямар арга замаар олж авах вэ гэдэгт хүн төрөлхтний танин мэдэхүйн түүх зориулагджээ. Тиймээс Буддын философи судлаач, доктор, профессор Г. Лувсанцэрэн «Сэтгэлгээний эрх чөлөөг эрхэмлэн буй өнөөгийн нөхцөлд монголын философи, нийгэм-улс төрийн сэтгэлгээ, түүний дотор Буддын философи, логикийн үзлийг судлан боловсруулж, нийтийн хүртээл болгохын ач холбогдол өсөж байна. Буддизм бол дан ганц шашин бус, дан ганц шинжлэх ухаан буюу философи бус аа. Буддын шашин дэлгэрч, нийгмийн амьдралын бүх талд нь гүнзгий нөлөөлсөн орнуудад хөгжиж байсан соёл, шинжлэх ухааны мэдлэгийн өв санг шашны хамтаар «буддизм» гэдэг нэгэн нэрийн дор нэгтгэн ойлгох болсон» (Лувсанцэрэн, 2001) хэмээн цохон тэмдэглэжээ.

Монголын орчин үеийн уран зохиолд аавын тухай олон мянган туурвил буй. Бид эл сэдвийн хүрээнд 60 гаруй зохиолч, яруу найрагчийн 100 орчим бүтээлийг шинжилж үзэхэд аавын гадаад дүр төрх, нас намба, сэтгэл санаа, зан төрх, энэрэл хайр, ач гавьяа, үрээ гэсэн чин сэтгэл гэх мэт олон өнгө аяс илэрч байна. Жишээ нь: Яруу найрагч О. Дашбалбар 1991 онд хэвлүүлсэн «Бурханы мэлмий» номоо «*Хайрт эцэг Ж. Очирбатын гэгээн дурсгалд зориулав*» гэсэн нь ааваа гэх хүүгийн чин сэтгэлийн илрэл, дурсаад дурсаад нөхөгдөхгүй гүн харуусал, дуудаад дуудаад харахгүй

хүмүүн заяаг зөөллөсөн сэтгэлийн урсгал юм. Энэ нь ганц нэг шүлэг, найраглалаар үл хязгаарлан томоохон бүтээлээ дотны хайрт хүндээ нэр заан зориулдаг болсон нь «Бүтээл зориулал»-ын бодит жишээ болж байна. Яруу найрагч *«Хамгийн хайртай од минь долоон бурхан, гурван марал, хамгийн дуртай өнгө улбар шар, тунгалаг цэнхэр, хамгийн хайртай хүн аав минь байв»* (Дашбалбар, 1991) гэсэн байдаг. Тиймдээ ч аавдаа «Бодол» шүлгээ зориулсан бөгөөд түүнийг дахин хэзээ ч харахгүй болсноос хойш амьдралын минь жинхэнэ баяр баясгалан үгүй болсон хэмээгээд «Элегия» буюу гашуудлын шүлэг бичжээ. Уг шүлгээ эцгийнхээ гэгээн дурсгалд зориулсан нь тухайн хүний сэтгэл зорхний мөн чанарын илэрхийлэл болно.

Монголын орчин үеийн уран зохиолд эцгийн дүрийг бүтээхдээ:

1. *Аавынхаа ачийг санан, хариулах юмсан гэх үрийн дотоод сэтгэлийн хүслэн*
2. *Аавын гэгээн дүр, өөр зуурт хоногшин үлдсэн нандин дурсамж*
3. *Алс холоос эцэг эхээ дурсан санасан сэтгэлийн өчил*
4. *Хайрт эцгээсээ хагацан салсан гунигийн өнгө*
5. *Эцгийн элбэрэл хайрыг бахдан дуулсан баяр баяслын цэнгэл*
6. *Аавыгаа аливаа муу хүчнээс өмгөөлөн хамгаалсан өмөөрөл*

гэсэн ерөнхий зургаан шинжээр товойлгон үзүүлсэн байна. Нөгөө талаас нь эцгийн зүгээс үр хүүхдээ гэсэн энэрэлт сэтгэл, тэднийгээ хүслийн жууз тэргэнд суулган амар жаргалантай амьдруулах гэсэн чин эрмэлзлийг ч бас харж болно. Оросын утга зохиол судлаач В. Г. Белинский «Нэгэн ухагдахууныг ав адилхан илэрхийлэх тийм хоёр үг нэг хэлэнд байх учиргүй» (Белинский, 1947) гэж аливаа зүйлийг илэрхийлэх хэлний олон боломжийг нээж ашиглах нь зохиолчийн уран чадварт хамаатайг онцлон тэмдэглэжээ. Үнэхээр зохиолч, яруу найрагч бүр өөр өөрийн гэсэн аавын дүрийг дахин давтагдашгүй урласан байдаг.

Монгол хүн эх эцгээ энэ дэлхийд юунаас ч илүү ачлан хүндэлж түүнийг олон зууны турш утга уянгын мөнхийн сэдэв болгон дээдэлж, яруу найргийн сэтгэлгээний мөр бадгаа зориулж ирсэн. Төрийн хошой шагналт, зохиолч Д. Намдагийн «Аав, ээж хоёр» (1946 он) шүлэгтээ,

Зол гэдэг бол — эцгийн илч

Заяа гэдэг бол — эхийн ач гэсэн санааг гаргажээ. Зол, Заяа хоёр бол эцэг эхийн үүсгэсэн амьдрал, энэ бол байгалийн хууль, амьдралын жам болох тул эцэг эхийн ачлалыг эрхэмлэн үзэх ёстойг дэвшүүлэн тавьсан байна. Харьцуулан үзэхэд, **эцгийн хайр** — энэрлийн өгүүлэмж, **эхийн хайр** — элбэрлийн өгүүлэмжээс бага дүрслэгдсэн нь үнэн боловч агуулгын хүрээ, дүрслэлийн бодомжуудаараа дутахгүй юм. Эхийн сэдэвт шүлгүүдэд энэрэл хайрын талыг голчлон өгүүлдэг бол эцгийн сэдэвт шүлгүүдэд — аавын саруул ухаан, уужим бодол голчлон өгүүлэгддэг байна.

Яруу найрагч Д. Гомбожав «Хангай шиг түшигтэй аав минь» (1955 он) шүлэгтээ, *«хазайхад минь тулдаг, хэлтийхэд минь түшдэг эрдэнэ шиг сургаалтай аав минь»* гэж урласан бол М. Ширчинсүрэн мөнгөн буурал аавынхаа уужим сэтгэлийг дүрсэлж «Аавын бодол» (1958 он) шүлгээ бичсэн байна. Яруу найрагч Л. Хуушаан «Миний эцэг» (1956) шүлэгтээ эцгээ дурсан буй хүүгийн сэтгэлийн өгүүлэмжээр дамжуулан,

Бөртйх сэв үгүй ариун цагаан сэтгэлтэй байсан

Бүх амьдралдаа худал хэлэхийг жигшдэг байсан

Үнэнээр явахад үнэн сэтгэл хэзээд бүтнэ гэж

Үргэлж бидэнд Та сургаж захидаг байсан сэтгэлийг илэрхийлжээ.

Д. Гомбожавын «Чимхүүр» (1956 он) шүлэгт, ааваасаа үлдэж хоцорсон чимхүүрийг амь шигээ хайрлан байдаг хүүгийн сэтгэлийн дотоод нууцыг тайлахдаа энэ бол элбэрэл журам, энэрэл хайрын бэлгэ тэмдэг болж буйг өгүүлсэн нь содон сэтгэмжтэй болжээ. Үүгээрээ шүлгийн гол санаа нь *«Ертөнцийн хүн бүр эцэгтэй байдаг боловч ер нь миний аав шиг хүн байхгүй биз»* гэсэн яруу найрагчийн хэлсэн мөрөнд илэрч байх бөгөөд энэ үгнээ хүүгийн сайхан сэтгэлийн халуун элч, хайрлан энэрэхүйн их хүч шингэсэн байна.

«Үртэй хүн үхдэггүй, үндэстэй мод хувхайрдаггүй» гэсэн өвгөдийн сургаал ёсоор өөрийнхөө нэрийг аавынхаа нэртэй хамт дэлхийд өргөж явааг Ш. Цэнд-Аюуш дүрслэхдээ,

*Улсын шалгалтанд орохоор нэрийг минь дуудахад
Урд нь аавын нэр дуудагдаж
Урамышил шагнал олгож, нэрийг минь онцлоход
Урьдаар заавал аавын нэр дуудагдаж
Хэрэгт орооцолдоод нэрийг минь дуудахад
Хэрэг хийлцсэн юм шиг хамт дуудагдаж
Амжилт гаргаад хэвлэлд бичигдэхэд
Аанай л бас нэртэй минь хамт бичигдэж,
Хайрт аавын минь алдар нэр
Хамт надтай явж байдаг*

хэмээн өөрийн оюун сэтгэхүй, хийж бүтээхүйн хүч нь урьд урьдын эцэг өвгөдийн уламжлал, увдис ерөөлийн буянаар энэ биед оршиж, сэтгэл ухамсрын дотоод хүч, бие махбодынхоо бүтэц бүрэлдэхүүнийг танин ухаарсны үр дүнд сав, шим ертөнцийн уг язгуур, учир зүйг танин мэдэх учиртай тул аав, ээжийн нэрийг сэвтээхгүй явахыг чухалчлан шүлэглэсэн байна.

Даг. Жамъяангийн «Аав таныгаа дуулнам» (1961), Т. Юмсүрэнгийн «Буурал аав» (1966), Б. Цэдэндамбын «Жаргаагүй зүрхэн» (1967) зэрэг шүлэгт эцэг хүний энэрэл хайрыг үнэн мөнөөр илэрхийлжээ. Сэтгэлийн олон янзын төрх байдал, тэдгээрийн мөн чанарыг үүсгэл үүтгэл, ахуй үесийн байдал, зорин үйлдэх нөхцөл шалтгаан нээн гаргахад шинэ өгөгдөхүүн, харьцуулах зүйлийг тодруулахад анхаарсан байна. *«Амьдралын гэгээлэг бүхэн аав аа гэж дуудахаас эхтэй»* (Н. Баянмөнх)-г ухаарч, аз жаргалд хүргэдэг аавын тухай дууны шүлгийн мөрүүдээс дурсамж хөвөрнө. «Аавын ухаан дутаж байхыг үзээгүй, аавын хийморь гундуухан байхыг хараагүй» (Н. Энхбаатар) гэсэн хүслийн цагаан манан амьдралын үнэнтэй улаан нүүрээр учруулахаас бага ч атугай холдуулж байгаад урлагийн «хуурамч» өнгө тодорно.

«Тийм ээ! Монголын яруу найргийн тэнгэрт О. Дашбалбар, Д. Нямсүрэн, Д. Батбаяр, С. Эрдэнэ, Д. Урианхай... хэмээх их хүмүүс бүтээн туурвиж байхад, Д. Норов гуайн «Мөнхийн дуудлага» тууж миний ширээн дээр байхад Монголын яруу найргийн заяа тэнгэр үнэхээр их гэдэгт хэн эргэлзэх билээ» (Энхбаяр, 1995: 38). Тэр тусмаа аавын тухай чин үнэн үгтэй зүрх сэтгэлээс гарсан шүлэг дуун эгшиглэж байхад...

*Үрчин уруулаа цорвойж ч чаддаг... аавтай байлаа!
Үүлэнд асах аянга шиг нирхийдэг ч байлаа
Үдээтэй дараатай судар шиг нам жим болохдоо ч болдог л байлаа
Үйлс урагшигүй юм хийгээд зовхий нь унагахад
«Үхээд хардагч болоосой, чамайг!» гэж санаа алддаг ч л байлаа! (Д. Урианхай)*

гэсэн шүлгийн мөр харж суухад мөнх л санагдах хорвоогийн харамгүй хэрнээ барих барьцгүйг сануулж, хамтдаа байхын цагт хагацахаа олтгойддог, хайрлах, хайхрахаа үргэлж хожиддог хүний үрийн сэтгэлийн «хүнд манан»-г сөхнө.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Мөнх бус орших аав, дайн

Эх орон, элгэн садны тухай ярихаар заавал ч үгүй аавын тухай яриа хөндөгддөг. Эр хүн, эцэг хүний дайчин баатарлаг чанар, эх орноо гэсэн сэтгэлийн хатан зоригийг магтан дуулсан шүлэг яруу найраг монгол яруу найргийн түүхэнд элбэг тохиолдоно. Дайны хор хөнөөл, эх орноо гэсэн эр цэргийн цээжинд хэрхэн төсөөлөгдөж байсныг дүрсэлсэн яруу найргийн талаар үл өгүүлэн өгүүлье.

Ч. Чимэд «Тэр цагт» (1965), Д. Шагдарсүрэн «Зүрх мартахгүй» (1968), Д. Пүрэвдорж «Цэрэг танаа» (1965), Ж. Шагдар «Шаахай» (1970), С. Оюун «Эр цэргийн гэргий» (1972) зэрэг шүлэгт «ганцхан олдох насаа өгөөд газар дэлхийн шархыг нөхөөд галын дайныг аваад явсан эргэж ирээгүй эр цэргийг зүрх мартахгүй»-н (Д. Шагдарсүрэн) учрыг өгүүлж байна.

Яруу найрагчид дайныг эсэргүүцэн энхийг эрхэмлэх тухай нэгдмэл санааг өөр өөрийн урлах эрдэм, уран сайхны сэтгэлгээний цар хүрээгээрээ өвөрмөц сонин дүрслэлээр илэрхийлсэн юм. Энэ сэдвээр бичигдсэн Д. Нямаагийн «Аав, дайн хоёр» (1966), «Освенцимд авахуулсан гэрэл зураг» (1974), «Тутаргын тариан дунд онгоц уналаа» (1969) зэрэг шүлгүүд дайны хор хөнөөлийг харуулах зүйлийг оновчтой сонгон цөөн мөрөөр маш гүн гүнзгий утга санааг илэрхийлэн бичсэнийг жишээ болгон «Аав, дайн хоёр» шүлгээс үзье:

*Аавыг минь
Дайн аваад явсан
Аав минь
Дайныг аваад явсан
Аав дайн хоёр
Аль алиныгаа
Амьд үлдээгээгүй*

гэж дайны улмаас эцгээсээ өнчирч хоцорсон хүүгийн бодол, сэтгэлийн илэрхийллийг оновчтой цөөн үг, үгийн утгын сонголт, монгол хүний сэтгэлгээний онцлогийг харуулж чадахуйц дүрслэлээр илэрхийлж өгчээ.

Мөнх орших аав, ажил

Эр хүний хөдөлмөрч чанар, эцэг хүний үр хүүхдээ гэсэн сэтгэл, амьдрал ахуйгаа хөтөлж ирсэн түүхэн уламжлал, хөдөлмөрийн амт шимтийг мэдэрсэн хөдөлмөрч зан чанарыг магтан дуулсан шүлэг яруу найраг манай зохиолч, яруу найрагчдын голлох сэдвийн нэг болдог. Яруу найрагч С. Дашдооров ажилчин хүний хөдөлмөрч чанарыг уран сайхны тодорхой дүр, дүрслэлээр нээн харуулж бичих талаар 1960-1980 оны монголын орчин үеийн яруу найргийн түүхэнд томоохон байр эзлэх «Уурхай» (1960), «Өглөө» (1962) «Галч» (1961), «Дархан» (1962) зэрэг шүлгээ туурвисан билээ. Түүний «Галч» шүлэг нь Б. Явуухулангийн «Түлээчин»-ий нөлөөгөөр бичигдсэн нь тодорхой.

*Нүүдэлч овгийн өвгөн галч
Нүүрс хутган нийшинд шиднэ
Хатуу нүүрс дарь шиг авалцаж
Хайлмаг ган шиг улайн цэвцийнэ,
Галчийн түлсэн галын илч
Газар доогуур хавж гүйнэ
Бавгар өвгөний сэтгэлийн илч
Бас л түүнтэй барилга дамжина*

хэмээх дүрслэлээс харахад уг шүлгийн өвөрмөц онцлог нь галын илч халуунтай сүл-
элдүүлэн хөдөлмөрч өвгөн хүний дүрийг нүдэнд ил үзэгдэхүйц түүний хөдөлмөрөөр
чангарсан биеийнх нь булчин зэргийг хөшөө мэт товойлгон дүрсэлсэнд оршино.

Эцгийн элбэрэл журмын сэдэв өгүүлэмжийг ингэж өргөтгөн түрж ганц биений
бодол хүсэл биш, нийт олны амьдрал тэмцлийн талбайд дэвшүүлэн гаргасан явдал
манай үеийн шинэ хүн болсон яруу найргийн ертөнцийг үзэх үзлийн өөдрөг шинжийг
илтгэж өгнө. Б. Хаянхярваа «Анчин аав минь» шүлэгтээ,

*Алтан нарны туяа анх түрүүн тусдаг
Аглаг баян хангайнхаа сэрүүн оргил дээр
Алсыг харуулданхан сэтгэл юугаа сэргээж
Анчин аав минь өдийд олзтой яваадаа
Оройн хонь хотлохын өмнөхөн
Орчлонгийн нар шингэх агшинд
Омгolon хээрийнхээ зоог хотолзуулан
Олз омогтой ирнэ, анчин аав минь
Эрмэг насаа атираа нугачаанд нь элээсэн
Эцэг минь хан хорвоодоо хайртай юм
Элбэг ангийн сайхнаар ганзага юуг нь мялаасан
Эх нутаг нь ч аавд минь ээлтэй юм даа*

гэж яруу найрагч маань аавыг дүрслэн бичихдээ ажил амьдралын үйлд тулгуурлан
бичжээ. Иймдээ ч бид,

*Баян хааны уулс аа
Бугын урамдаат хөвч өө
Анхны цаснаар яарамтгай
Анчин аавын нутаг аа (Б. Сундуй) гэж сэтгэлээ шимшрүүлэн дуулах дуртай.*

Хүний амьдралд тохиолддог бүхэн яруу найрагчийн бүтээлд их бага ямар
нэг хэмжээгээр туссан байдаг. Зохиолч Ш. Дулмаа «Аав минь ажилсаг хүн байлаа»
хэмээх шүлгээ *Эцэг Шагдарын гэгээн дурсгалд зориулжээ*. Үүнд,

*Үүрийн гэгээнээр адуундаа мордож
Үдийн халуунаар айргаа бүлж
Үдшийн сэрүүнээр сураа элдэж
Өдрийн турш л завгүй байдагсан
Тээр тэнд, гэрийн хаяанд шүүлсэн арьс
Тэрэгний сүүдэрт тосолсон сур
Ширдэг доор нь ханын үдээс
Өвдөг дээр нь хар суран ногт,*

*Нэг л харахад нэхий элдэж сууна
Нэлээд удсаны дараа чөдөр зангидна
Тэгснээ больчихоод, уургаа тагнайдна*

Тэгээд бас арьс элдэнэ хэмээн аавынхаа наян жилийн хугацаанд туулсан амьдрал, цаг завгүй ажиллаж байсан их хөдөлмөрийг нь бахдан дуулж, дурсан бичихдээ ер нь л нийтлэг монгол эр хүний хийдгийг хийж явсан гэх шиг, эсвэл ажил үүргийн хуваарийг нь бүр ч тодруулж буй шиг тоочин өгүүлсэн.

Д. Намдагийн «Аавын оролдлого» шүлэгт аавыг ямар хэрэгтэй хүн байдаг тухай илэрхийлжээ. Уг шүлэг нь аавыг ямар нэгэн зүйлтэй адилтгаж зүйрлээгүй байна. Зөвхөн амьдрал дээр байгаа зүйлийг уран тодоор яруу сайхан бичсэн бол Б. Хүрэлбаатар «Аавдаа өргөсөн шүлгэн зул» шүлэгт,

*Өрнө, Дорно руу хэт хазайж
Өөрийгөө эвдээгүй монгол хөдөөд
Өвгөдийнхөө галын дэргэд
Өрөөлд атаархаагүй
Өөртөө зөв амьдарсан аав минь
Ах дүү нь бүгдээрээ
Хот хот гээд нүүцгээхэд
Ангиртынхаа голд хонио хариулсаар хоцорсон аав минь
Найрын хоймроос дээлийн торго дэлгэн
Дөчин бэр ёсолж мөргүүлсэн аав минь
Наадмын хоймор торгон жолоо өргүүлж*

Дэлтэй морьдоо цоллуулж явсан аав минь гэж унаган нутаг ус, ахуй амьдрал, малчин айлд байх нандин чанарыг илэрхийлсэн бөгөөд мөн аавдаа зориулсан «Уулын хоньчин» шүлэгт энэ санаагаа баталсан байна. «Аавдаа өргөсөн шүлгэн зул» шүлгийн төгсгөлд;

*Ганц хүүгээрээ толгойгоо түшүүлж
Бурхан болсон буянтай аав
Гурван төрийн нүүрэнд
Нударгатай дээлтэй явсан аав минь
Гуних баясахын алинд ч
Нуруутай амьдарсан аав минь*

гэснээс үзэхэд бурхан болсон аавыгаа дурсан санасан дүр зураглалыг эл шүлгээс нь тодруулж болох юм. Нөгөө талаар, яруу найрагчид аавын их ачийг амьдралын их сургууль хэмээн үзэж аминаас үнэтэй, амьдралдаа хайрлах эрдэнэ болохыг өгүүлж тэр чанар нь хүүгээ хүний зэрэгтэй явуулах гэж хүсэн мөрөөдөж явдаг хөөрч буурахгүй халуун сэтгэлд байгааг ихэд онцлон дүрсэлсэн байна. Ажил хөдөлмөр хийж, амьдрал ахуйгаа залгуулж явсаар ард нь тэд нэг л өдөр үр хүүхдийнхээ сэтгэл зүрэнд «Аав уул», «Аав мод», «Аав бурхан» болон оддог тухай,

*Аав минь одоо мод болсон
Амраг хосуудын мод болсон
Намар оройн навчсан дунд нь хөлбөрөхөд
Нас нэмэх сэтгэл болсон*

Аав минь одоо мод болсон... (Ш. Лхамноржмаа) гэж омог бардам хэрнээ сэтгэлд гунигийн аяз мэдрүүлэн мэдрүүлэн бичжээ.

Мөрөөдлийн жигүүртэй ур маяг

Аавын тухай шүлгүүд өгүүлбэрзүйн ур маяг, бүтэц, зохиомжийн хувьд монгол шүлгийн онцлогийг хадгалсан байхын дээр зарим нэг санааг гаргахдаа өвөрмөц сонин шийдлийг агуулсан байна. Б. Явуухулангийн «Амар» шүлэгт,

*Амар гэдэг нэртэй хөөрхөн хүүтэй болоод
Анчин аавынхаа ачийг эргэн нэг дурсав
Анчин аавынхаа ачийг эргэн нэг дурсахдаа
Хүйтэн асганы ёроолд дэвсэн хэвтдэг байсан
Хөлстэй нимгэн тохомд нь хайрагдах шиг болов*

хэмээн өгүүлбэрийг эхэнд нь давтан бэлчирлүүлэх маягийг сонгосон бол Л. Мөнхтөр «Зөөлөн зөөлөн замбуулин» дууны шүлэгт,

*Агь үнэртсэн цэнхэр талын
Адуу нь дандаа соргог байдаг
Уужуу тайван ухаантай аавын минь
Үг нь дандаа эрдэнэ байдаг
Зүүд хүртэл жаргааж сэрдэг
Зөв явахад зөөлөн зөөлөн замбуулин*

гэх зэргээр бүхэл бүтэн өгүүлбэр буюу бадгийг давтаж ардын дууны эн зэрэгцүүллийн аргаар урлан бичжээ.

Д. Нямсүрэнгийн «Дөрвөн цаг» шүлэгт:
*Тооноор цас будран орох нь сайхан
Тогооны таган дээр унаад хайлах нь сайхан
Гэрийн хойморт аав суух нь сайхан
Гэрэлтэй үүдээр ээж орж ирэх сайхан*

хэмээн амьдралын эгэл энгийн үзэгдлийг, гэрээ дүүргэн ханхайж суугаа аавын дүр төрхийг ажин түжин хөдөөгийн цас орж буй намуун ахуйтай уялдуулан дүрсэлсэн нь аавын ухааны алс, бодлын гүнийг гаргахад тохиромжтой болжээ.

Ардын уран зохиолч Д. Пүрэвдоржийн «Хөх даалимбан тэрлэг» найраглалын «Бүүвэйн дуу»-нд:

*Адуучин аавын хүү билээ
Агтны тоосонд төрсөн билээ
Алимнаас ургасан алим билээ
Аминаас ургасан амь билээ
...Аавын үгүйд аав болсон
Ард олноо хайрлаж яваарай
Асар их үнээр олдсон
Аз жаргалаа хамгаалж яваарай*

Яруу найрагч Р. Чойномын «Аав бидэн хоёр» найраглалд эцэг хүү хоёрын харилцааны нандин холбоо, тэдний сэтгэли хөдлөл, амьдралыг танин мэдсэн туршлагаасаа шалтгаалсан харилцааны зөрчил, эцгийн зүгээс хүүгээ сурган хүмүүжүүлж буй уламжлалт хүмүүжлийн арга, түүнээс сургамж авсан хүүгийн дурсамж сэтгэгдлийг зураглан гаргажээ.

«Аавыгаа хүлээж бичсэн шүлэг»-ийг яруу найрагч Даваасүрэнгийн Чинзориг бурхны оронд одсон аавыгаа хүлээж, хажуу дэргэд морьтойгоо, хан буурал нутагтаа, өөрийнхөө дэргэд байгаа сэтгэмжээр бичиж, хүмүүний аав сэтгэл зүрхэнд мөнхөд оршин байдгийг уран яруу дүрслэн бичжээ.

*Тоосны үзүүрээс аавыгаа харах гэж зөнгөө хуурна
Товолзтол хатируулсаар мөдхөн ирнэ гэж сэтгэлээ аргадна
Тэнгэрт одсон аавыгаа ирнэ гэж хүлээж суудаг*

*Би аавтай хүн! гэх халгиун цалгиун шүлгийг бичсэн Хайдавын Чилаажавыг
«Аавдаа би хайртай» дуугаар нь илүү хүндэтгэдэг бөгөөд эл шүлэгт,
Намрын бороо зөөлөн шиврэхэд аав минь дуртай
Насыг нь зөөж буцаар л яваа шувуудад хайртай
Өөрөө өтлөвч орчлонд үлдэнэ гэж надад хайртай
Өдрөөс өдөрт холдсоор яваа аавдаа би хайртай*

хэмээн нэг л намар миний ижил залуухан явсан эцэг минь эргэх хоногуудын эргэлтэд өтөлж буй гунигт аязыг эгшиглүүлж, хүний амьдралын улирч хувьсдаг мөн чанарыг гүн ухааны сэтгэмжтэй сүлэлдүүлэн бичсэн байна.

Яруу найрагч В. Батбаяр «Зуны шүлэг»-тээ,

Миний бор аав

Дэлгэрч эргэдэг жамын

Дэлхийтэй нийлж наслан

Нялх унаганы туурайн зайд

Халх талын цэцэг болон

Ирж байгаа юм

хэмээн нуур ус шувуудаар дүүрч, нуруу бэл цэцгээр дүүрч, адуу сэргэлэн дэнжид хорж, айлууд тогоогоо нэрээд ирэхлээр, агь сэнхийлгэн дөрөө гишгэж, ат дэнхийлгэн нүүдэл хөтөлж, дулаахан амьдралын тэргүүн явсан, дууриал нөмөртэй аавыгаа,

Ханын эвтэй хотол дундаа

Малын хишигтэй нутаг дундаа

Зулын өргөлтэй хоймор дундаа

Зунилага асуужээ суугааг санадаг хүүгийн сэтгэлээ үгүй хойгуур нь мартаж сандаахдаа эд зүйлсээ эмхэлж хүн болдог жамыг ухааран шүлэглэжээ.

Үүнчлэн, Ц. Хулан сайхан залуу аавынхаа тэргүүнд буурал орсныг анх үзээд саваагүй томоогүй хүүхэд насаа тэр жилийнх нь шувуудтай хамт буцаасан, санчигт нь нэмэгдэх мөнгөн сорны тоолонд жаргаана даа тэгвэл гэхэд санаснаар даанч болохгүй яваагаа,

Бүүвэйт хонгор ижийн тухай дуу мэдээж олон

Бүдэгхэн гардаг зураг шиг санаатай хийдэг алдаа шиг

Бүхий л орчлонд харин аавын ач гэж дуулдаггүй

Бүгдийнх нь аав ямар миний аав шиг биш дээ

хэмээн үнэн мөнийг ухаарсан ухаарлаа шүлэг болгон хайлжээ.

Мөн монголын уран зохиолын нэгэн салаа мөчир болох хүүхдэд зориулсан уран зохиолын зүйлд аавын тухай дүр дүрслэл цөөнгүй бий бөгөөд энэ тухайд хүүхэд багачуудын сэтгэлд орших аавын дүр төрхийг дүрслэн гаргаснаараа онцлог юм. Хүүхдэд зориулсан шүлгийн онцлог нь богино үгс, харилцан яриа, хэлний аялгыг их шаарддаг гэдгийг Ж. Дашдондогийн «Аав» шүлэгт:

Аваас би

Асуулаа

Аав аа

Аав аа

*Өөрөө та яагаад
Өндөр болсон юм бэ?
Аав надад
Хариуллаа.
Алсын уулсын барааг
Аав нь хүүдээ харуулах гэж
Өндөр болсон юм даа*

гэх мэтчилэн аялга, аялга үг, өгүүлбэрийг оновчтой хэрэглэжээ. Мөн толгой, сүүл холбосон шүлэг нь хүүхдийн хэл яриаг хөгжүүлэхэд тустай. Харин үргэлжилсэн үгийн зохиолын хувьд өгүүлбэр нь богино, гишүүдийн байрлал нь зөв, голдуу харилцан ярианы аргаар бичсэн байдаг. Гэхдээ хүүхдийн нас сэтгэхүйн онцлогтой холбоотойгоор найруулга сайтай, үг өгүүлбэрийн тоо их, хүүхдийн хэл яриаг хөгжүүлж, найруулах бичих чадварыг сайжруулах үлгэр дуурайл бүхий зохиол бүтээл бас байж болдог.

ҮР ДҮН

Мөнгөн туйлаадас шиг мөрүүд

Дорно дахины гүн ухаанд сэтгэлтэй холбогдох зургаан төрөн түгэхүй (мэдрэхүй) байхаас гадна биеийн мэдрэхүйн эрхтний үйл ажиллагааны үр дүн буюу тусгал хэрхэн дамжин тархдаг байдлыг илэрхийлсэн биетэй холбоотой зургаан төрөн түгэхүй байх бөгөөд энэ нь дүрсийн цогцтой холбогдон гарч ирдэг юм. Буддын эх сурвалжид: «Тийн мэдэхүй алин хэмээвээс тийн мэдэхүйн зургаан чуулган бөлгөө. Нүдний тийн мэдэхүй хийгээд чих ба хамар, хэл хийгээд бие, сэтгэлийн тийн мэдэхүй болой» гэсэн байх бөгөөд түүнийгээ нэг бүрчлэн дэлгэрүүлэн үзүүлэхдээ:

⇒ Нүдний тийн мэдэхүй алин хэмээвээс нүдэнд шүтэж, дүрсэд зорьж тус тус тийн ухах болой.

⇒ Чихний тийн мэдэхүй алин хэмээвээс чихэнд шүтэж, дууд зорьж, тус тус тийн ухах болой.

⇒ Хамрын тийн мэдэхүй алин хэмээвээс хамарт шүтэж, үнэрт зорьж, тус тус тийн ухах болой.

⇒ Хэлний тийн мэдэхүй алин хэмээвээс хэлэнд шүтэж, амтад зорьж, тус тус тийн ухах болой.

⇒ Биеийн тийн мэдэхүй алин хэмээвээс биед шүтэж, хүрэлцэхүйд зорьж, тус тус тийн ухах болой.

⇒ Сэтгэлийн тийн мэдэхүй алин хэмээвээс сэтгэлд шүтэж, номд зорьж, тус тус тийн ухах болой» хэмээн дурдсан бий.

Дээрх зургаан тийн мэдэхүйн эхний тав нь мэдрэхүйн гадаад таван эрхтнээс сэтгэлтэй холбогдох харилцаа хамаарлын үр дүнд үүссэн мэдрэл төсөөлөл буюу ерөнхийдөө сэтгэлийн объекттой харьцсан тусгалын үр дүнг илэрхийлсэн хэрэг юм. Эцсийн зургадугаар сэтгэлийн тийн мэдэхүй нь гадаад таван мэдрэхүйн эрхтний тийн мэдэхүйн үр дүн буюу өөрийн дотоод ухамсрын нөлөө хамаарлаас бий болсон сэтгэлийн субъекттэй харьцсан тусгалыг илэрхийлсэн хэрэг.

Харин дотоод, гадаад сэтгэл (далд ухамсар, ухамсарлагдсан байдал)-ийн харилцан нөхцөлдөх байдлыг илэрхийлэх шаардлагын улмаас зургадугаар сэтгэлийн тийн мэдлийн шүтээнийг томьёолохын тулд «сэтгэлийн язгуур»-ыг үндсэн

зургаан тийн мэдэхүйн язгуур дээр нэмж, нийт сэтгэлтэй холбогдох сэтгэлийн долоон язгуурыг тоочин үзүүлжээ. Нөгөө талаас мэдрэхүйн эрхтэнтэй шууд холбогдох таван тийн мэдэхүйн язгуурын шүтээн тус тусынх нь эрхтэн болох бөгөөд сэтгэлийн тийн мэдэхүйн язгуурын шүтээн нь зургадугаар эрхтэн буюу сэтгэлийн (дотоод) эрхтэн гэж үздэг юм.

Сэтгэлийн тийн мэдэхүй буюу зургаа, долоо дахь мэдрэхүйг хамгийн ихээр агуулсан сэдэв нь эцэг эхийн элбэрэл хайр юм. Олон олон шүлэгч ухааны тэнхээ, үгийн урнаа дайчлан сэтгэл зүрхнээсээ хандан бичдэг учраас манай яруу найрагт эх эцгийн тухай цөөнгүй сайхан бүтээл байдаг бөгөөд ялангуяа, тэнгэр адил саруул ухаантай далай мэт уужим сэтгэлтэй, амьдралын сургаал сургамжлах тухай эцгийн дуулал нь цөөнгүй байдаг.

Д. Гомбожавын «Чимхүүр» (1963), П. Пүрэвсүрэн «Эцгийн гар» (1963) шүлэгт эцгийн ач, энэрэл хайрын тухай тодорхой зүйлээс санаа авч илэрхийлсэн бол Б. Бэгзсүрэн «Аав» шүлэгтээ:

Аав гэдэг нэр зүүхийн төдий амар биш

Алив нэрний овог болох төдийхөн биш

Аав гэдэг нэрэнд алаг үрийн заяа бий

хэмээн «аав» гэдэг нэр хичнээн хүндтэй агаад сэвтээж болохгүйг өгүүлсэн бол

Н. Нямдорж «Аавын сургаал» шүлэгтээ:

Тогтоож авах нь толгойтой хүнд

Тос болохоор, тус болохоор

Тун ч их юм сургадаг гэж аавынхаа сургаалыг санан санан бичсэнээс сэтгэлд уяатай явдаг аавын хэлэхүй буюу амьдралын мөн чанар тодорном.

Б. Лхагвасүрэн «Тэр хөх мөнхийн уул- миний хүүгийн уул» (Ачит эцэг Бавуудаа, 1980) шүлэгтээ:

Ургах нарыг духдаж дүнхийнэ

Унах нарыг үүрч ханхайна

Наран шингэдэггүй

Навч нь ганддаггүй

Хөх мөнхийн уул

гэж зохиолч эцэгтээ зориулсан шүлэгтээ аавынхаа сэтгэлийн догдлолыг илчлэн гаргасан аяс ажиглагдах бол,

Хүүгээ сайн явааг дуулаад

Дэргэдүүр нь дуулж өнгөрсөн

Дуулж байна лээ, миний хүүгийн хөх мөнхийн уул

Хөгшинөө нутаглуулчихаад

Дэргэдүүр нь уйлж өнгөрсөн

Уйлж байна лээ, миний хүүгийн мөнхийн уул

гэснээс үзэхэд жаргал, зовлон сүлэлдэн байдаг хүний амьдралыг «хөх мөнхийн ууланд» нэвт шингээн тэлмэн зэрэглээн дунд адуу шиг цовхчих тэр хөх мөнхийн уул адуун сүргийн дундаас чиний морь хэмээн унага ногтолж өгөхөөс ч илүү санагдсан нь шүлгийн өгүүлэмжээс илхэн байна. Тиймдээ ч агт мориноос илүү амьд байгалийг эрхэмд үзэх гэсэн санааг энд зориуд шигтгэж өгсөн байна. Тэгвэл, «Хүү» / Саранхөхөө/-дээ зориулсан шүлэгт,

Үр минь үр минь

Үүрийн туяаны үр минь

*Энэ монгол орны төлөө сумнаас зүрхээ нуухгүй зориг
Эс бүхэнд чинь шингээг гэж ижий тань өлгийг чинь хөдөлгөсөн байж таарна
Ийм л явж чи эс чадвал
Эцэг чинь хожим булшин дороо даарна*

гэх мэт дээрх шүлэгт «эхийн санаа үрд, үрийн санаа ууланд» гэдгийг чухалчлаад ээж хүн үр хүүхдийнхээ төлөө хичнээн их санаа зовниж явдгийг эс ухаарвал «эцэг чинь хожим булшин дороо ч даарна» хэмээн гайхамшигтай санааг сэтгэл цочирдохуйц аймшигтай өгүүлжээ. Мөн «Хүүдээ унших шүлэг»-т:

*Аав нь хүүгээ согтуу явахыг харахад
Алтан үрийн багана ганхаж байх шиг уйтай
Аавыгаа чи лав хоёр болгож үзэж байгаа
Нэг нь үхэхэд
Нөгөө нь үлдэх юм шиг дэвэрч байгаа
Чи бидэн хоёр хэн хэндээ ганцхан юм шүү, үр минь!*

гэсэн хэсэгт нэгэн агшин, тохиол хоёроор ургуулан гаргаж ирсэн амьдралын үнэнийг үгээр аргадаж ухааруулсан байна.

Түүчлэн, Д. Шагдарсүрэн «Эрдэнэ» /Хүүдээ зориулсан/ шүлэгтээ:
*Аавынхаа өгсөн ариун нэрийг
Амь шигээ хайрлаж яваарай хүү минь*

хэмээгээд энэ ертөнцийн чулуу бүхнийг эрдэнэ гэж нэрлэдэгүй, аавынхаа өгсөн нэрийг амь шигээ хайрлаж яваарай хэмээн сургамжилсан нь «дуудах нэрийг эцэг эх нь өгдөг, дуурьсах нэрийг өөрөө олж авдаг» гэсэн санааг дам давхартаа сургажээ.

*Ц. Эрдэнэ «Аавдаа» зориулсан шүлэгтээ,
Цэнхэр уулс хөх усны хязгаарт уяатай
Энхэр дулаахан миний хөх уул минь
Нар ээсэн энгэрт чинь ургаж төрөөд унаж нойрсохдоо*

Дэр хөх чулуунд чинь шүлгээ үлдээж дэлхийн төв рүү одъюу... гэсэн байдаг. Цэнхэр уулс, хөх усны нутаг, аав хоёроо дээдлэх сэтгэлээр бичсэн санаа тодорч байна.

П. Лувсанцэрэнгийн «Аавдаа» шүлэг нь эцэг хүний дүр төрхийг илтгэн харуулахад чухал байр эзлэхийн дээр «Ааваа гэж дуудаж энгэрийг чинь налж суугаад аминчлан яримаар санагдах үдэш орой байх юм» хэмээн эцэг хүний орон зай гэрт төдийгүй сэтгэлд үгүйлэгдэж байсныг сэтгэл шимшрүүлж уран дүрсэлжээ.

Ардын уран зохиолч Т. Галсан «Аавын магтуу» шүлэгтээ,
*Аашлах нь эгээ л асгал хур
Алгадах нь яг л эр хар сур
Амилсан цөөн бурхдын сур*

Аав минь наддаа хүмүүн-нар гэсэн нь өв тэгш дээд хүмүүн болгох гэж өршөөл, зэмлэлээр үрээ тэгшхэн жолоодон хүмүүжүүлдэг аавыгаа хатуу ширүүн, уужуу гүндүүгүй, зан байдлыг нь чадмаг дүрсэлсэн байх ба хайрлан энэрэх үзэл нэвт шингэсэн байна. Т. Галсангийн элбэрэл ачлал, энэрэл хайрын сэдэвтэй шүлгүүд нь утга санаа уран яруу тод томруун дүрслэлтэй хэн ч уншихад ээжийн сүүн сэтгэл, аавын уужим дүр нүднээ тод дүрслэгдэж байдгаараа онцлог юм.

Эл шүлгийг «Зохист аялгууны толь»-ийн зарим чимэгтэй холбон авч үзэхэд сонирхолтой дүр зураг гарч байна. Хураах адилтгал нь хоёр юмыг ижилсүүлэхдээ ил нэг зүйлийг өгүүлж, чанад бусад далд зүйлийг нь бас адил байхаар

найруулах ухаан болно (Гаадан, 1986: 29). Дээрх шүлэгт, аав хүний аашлахыг «асгал хур»-тай, алганы амт өгөхийг «эр хар сур»-тай тус тус адилсгаж, сүүлчийн хоёр мөрөндөө дүрийг нь улам тодруулж, «Бурхдын сүр», «Хүмүн-нар» хэмээн илэрхийлэн хураасан байна.

	Аашлах нь	Асгал хур	
	Алгадах нь	Эр хар сур	
	Амилсан цөөн бурхдын сүр		
Аав минь наддаа хүмүн-нар			
Аав минь наддаа хүмүн-нар			
Амилсан цөөн бурхдын сүр			
	Алгадах нь	Эр хар сур	
	Аашлах нь	Асгал хур	

ДҮГНЭЛТ

Аавын тухай сэдэв нь монголын уран зохиолд чухал байр суурийг эзэлдэг. Уран бүтээлч бүрийн эн түрүүн бичих туурвих дуртай сэдвийн нэг бөгөөд нийгэм, түүхийн өөр нөхцөл, урт удаан хугацааны явцад утга агуулгаараа гүнзгийрэн, урлах эрдмийн хувьд баяжин хөгжсөөр өдгөөг хүрч ирсэн байна.

Аавын тухай сэдэвт бүтээлүүд нь монголчуудын ааваа гэсэн сэтгэлгээний илрэл, эр хүнийг эрхэмлэн үзэх уламжлалт үзэл, нуган үр, эрэгтэй хүүхдийг дээдлэн үзэх, гал голомт, эх орны тухай, үндэсний үзэлтэй заавал ч үгүй холбогдож байгаагаараа бусад сэдэвт бүтээлүүдээс өвөрмөц онцлогтой юм.

«Тэнгэр аав минь», «Бурхан аав минь» гэх мэт харуусалт үгсийг халаглах, харуусах сэтгэлийн өнгө аясаар ихэвчлэн хэрэглэж, дурсамжийн цагаан манан татуулсан байхын дээр аавын тухай дүрийн гол өгүүлэмжийг эцэг хүний нөмөр нөөлөг, холч ухаан бодол, захиа сургаал, үр хүүхдээ гэсэн сэтгэлтэй холбон уужим, уудам, дэлгэр, тэнгэр, далай мэт гэхчлэн энгүй их гэсэн гол дүр дүрслэлийг бий болгож байгаа нь аавын сэдэвт яруу найргийн гол онцлог болж байна.

Үнэн үг, жинхэнэ найраг гэдэг мөнх нас, үргэлжийн үнэлгээтэй, цаг үеч бус мөн чанартай байдгийг мартаж болохгүй... Монгол хүний ертөнцийг үзэх үзэл, сэтгэл зүй, зан чанарын давтагдашгүй шинжүүдийг нээх, монгол хүн бүр өөрийгөө хүн шиг амьдрах гэдэг үзэл санааг баталгаатай болгох шаардлага, цаг нэгэнт болжээ (Галбаатар, 1996).

«Нарлаг өндөр Алтайн ууланд

Намрын хяруу унаа даа

Настай буурал аав минь

Намайгаа харуулдан суугаа даа (Т. Юмсүрэн)

Ашигласан ном зохиол

а. Эх зохиол

- Бадарч Пунцагийн (1999). «Хөөрхий» найраглал. *МУЗД-65 (Монголын уран зохиолын дээж. Хойшид МУЗД гэх)*. Улаанбаатар. 198–201.
- Банзрагч Дашзэвэгийн (2006). «Хээр морьтой хүн». *Монголын сонгомол яруу найраг*. Улаанбаатар.
- Бархүү Нацагийн (1995). «Аавын хээр» шүлэг. *МУЗД-8*. Улаанбаатар. 32–33.
- Гаваасүрэн Лигдэнсүрэнгийн (2004). «Зүүдэнд уяатай аав» дууны шүлэг. *МУЗД-108*. Улаанбаатар. 168.
- Галсан Тангадын (1995). «Миний аав» шүлэг. *МУЗД-10*. Улаанбаатар. 269–270.
- Гомбожав Доржийн (2002). «Аав минь» шүлэг. *МУЗД-88*. Улаанбаатар. 111; «Аавын хацар» шүлэг. *МУЗД-88*. Улаанбаатар. 126.
- Давааням Данигайн (2004). «Аавын ухаан» шүлэг. *МУЗД-106*. Улаанбаатар. 425–426.
- Дагвадорж Чойсүрэнгийн (2003). «Аавдаа» шүлэг. *МУЗД-102*. Улаанбаатар. 71; «Хүү минь, би чамайгаа нэг их сайхан хайрлах гэсэн юм» шүлэг. *МУЗД-102*. Улаанбаатар. 76–77.
- Дашбалбар Очирбатын (2001). «Бодол» шүлэг. *МУЗД-74*. Улаанбаатар. 64–65; «Намрын ухаарал» шүлэг. *МУЗД-74*. Улаанбаатар. 78–79; «Сэтгэл, ухаан хоёр» шүлэг. *МУЗД-74*. Улаанбаатар. 244; «Элегия» шүлэг. *МУЗД-74*. Улаанбаатар. 92–97; «Ялан дийлэхийн ухаан» шүлэг. *МУЗД-74*. Улаанбаатар. 245.
- Дашдамба Цэрэнжамцын (2004). «Миний охины төрсөн өдөр» шүлэг. *МУЗД-107*. Улаанбаатар. 151.
- Дашдооров Сормууниршийн (1981). «Аавын үг». *Монголын шилдэг яруу найраг*. Улаанбаатар.
- Доржпалам Барнангийн (2002). «Юугаа ч хайрлаагүй аав аа» шүлэг. *МУЗД-88*. Улаанбаатар. 358.
- Доржцэрэн Навааншаравын (2004). «Аавууд» шүлэг. *МУЗД-106*. Улаанбаатар. 483.
- Дулам Сэндэнжавын (2004). «Өвөө маань тэр өдрөө...» шүлэг. *МУЗД-93*. Улаанбаатар. 154.
- Дулмаа Шагдарын (2000). «Аав минь ажилсаг хүн байлаа» шүлэг. *МУЗД-97*. Улаанбаатар. 125–127; «Эцгийн голомт» шүлэг. Улаанбаатар. 26.
- Жамьян Дагвын (1981). «Хүү минь». *Монголын шилдэг яруу найраг*. Улаанбаатар.
- Лхагвасүрэн Бавуугийн (1999). «Ачдаа үлдээх шүлэг». *МУЗД-62*. Улаанбаатар. 223; «Маргааш миний хүү цэрэгт мордоно» шүлэг. *МУЗД-62*. Улаанбаатар. 104–105; «Хүүдээ унших шүлэг». *МУЗД-62*. Улаанбаатар. 112; «Эр хүнийг хайрлаж яваарай» шүлэг. *МУЗД-62*. Улаанбаатар. 90–91.
- Пүрэвсүрэн Пүрэвжавын (1999). «Аавын захиа» шүлэг. *МУЗД-64*. Улаанбаатар. 59.
- Сумьяа Доржпаламын (2004). «Нутаг амьтай аав» дууны шүлэг. *МУЗД-107*. Улаанбаатар. 568.
- Сундуй Бат-Очирын (2004). «Ухаан хайрласан аав» шүлэг. *МУЗД-108*. Улаанбаатар. 330–334.
- Сундуй Оюунбадамын (2004). «Аав, хүү хоёр» шүлэг. *МУЗД-106*. Улаанбаатар. 551.
- Сүрэнжав Шаравын (1998). «Миний охин» шүлэг. *МУЗД-45*. Улаанбаатар. 277–279; «Энхрий жаахан охин минь» шүлэг. 281; «Нэг модны намтар» дурсамж. 36–37.
- Сэнгээ Дашзэвэгийн (1998). «Аавын захиа» шүлэг. *МУЗД-42*. Улаанбаатар. 32.
- Сэрээнэн Ономын (1995). «Үнэн хүү минь тэгдэг юм» шүлэг. *МУЗД-10*. Улаанбаатар. 380–381.
- Уянга Шагдарын (2004). «Аав» шүлэг. *МУЗД-108*. Улаанбаатар. 358–359.
- Хангайсайхан Хүрэн-Алагийн (2004). «Аавдаа бичих захидал» шүлэг. *МУЗД-98*. Улаанбаатар. 153.
- Хулан Цоодолын (2004). «Аавдаа» шүлэг. *МУЗД-108*. Улаанбаатар. 388–389.

Хуушаан Лувсамдамбын (2001). «Аав минь адуучин явсан түүх» найраглал. МУЗД-76. Улаанбаатар. 214–233; «Миний эцэг» шүлэг. МУЗД-76. Улаанбаатар. 133; «Эцгийн хайр» шүлэг. МУЗД-76. Улаанбаатар. 134.

Хүрэлбаатар Бямбажавын (2002). «Аавдаа өргөсөн зул» шүлэг. МУЗД-84. Улаанбаатар. 134; «Алс хол зориход аавын захисан үг» шүлэг. МУЗД-84. Улаанбаатар. 66; «Эцгийн гэрийн хоймор нар дагаж суугаад». МУЗД-84. Улаанбаатар. 95–96.

Цоодол Дөнгөтийн (2001). «Үр минь үр минь» шүлэг. МУЗД-72. Улаанбаатар. 79; «Орой Эрэн-цэн» шүлэг. МУЗД-72. Улаанбаатар. 299–304.

Цэдэндорж Мишигийн (1998). «Хүний мөр» шүлэг. МУЗД-51. Улаанбаатар. 218–221.

Чилаажав Хайдавын (2004). «Аавдаа би хайртай» дууны шүлэг. МУЗД-108. Улаанбаатар. 428.

Шагдар Жамцын (1981). «Аавын хайр». *Монголын шилдэг яруу найраг*. Улаанбаатар.

Шагдарсүрэн Данзанямын (2002). «Эрдэнэ» шүлэг. МУЗД-88. Улаанбаатар. 21.

Ширчинсүрэн Мишигийн (1998). «Аав үхэл бид гурав» шүлэг. МУЗД-54. Улаанбаатар. 162–164; «Уужим энэ дэлхийд эцэг шиг хүн байх нь ээ би» шүлэг. МУЗД-54. Улаанбаатар. 183–184; «Хоёр морь аав бид дөрөв» шүлэг. МУЗД-54. Улаанбаатар. 165–168; «Хүүгийн хөлийн чимээ» шүлэг. МУЗД-54. Улаанбаатар. 88–92; «Эцгийн гэрийн гал» шүлэг. МУЗД-54. Улаанбаатар. 175.

Эрдэнэбаатар Хөөдөөгийн (2006). «Урианхайн хөх уулс». *Монголын сонгомол яруу найраг*. Улаанбаатар.

Эрдэнэбат Лувсанчүлтэмийн (2004). «Хүүдээ хэлэх шүлэг». МУЗД-108. Улаанбаатар. 279.

Эрдэнэ-Очир Арлааны (2004). «Дорноговь руу галт тэрэг хөдлөхөд» шүлэг. МУЗД-108. Улаанбаатар. 506.

Явуухулан Бэгзийн (1998). «Эцгийн дурсгалд» шүлэг. МУЗД-34. Улаанбаатар. 1998. 90–92; «Тэхийн зогсоол» дууль. МУЗД-34. Улаанбаатар. 293–297.

6. Судалгааны бүтээлүүд

Байгалсайхан, С. (1995). *Уран зохиол шинжлэлийн удиртгал*. Улаанбаатар.

Батхуяг, П. (2006). *Яруу найргаар ярилцахуй*. Улаанбаатар.

Белинский, В. Г. (1947). *Избранные сочинения*. Т. 28, Москва.

Гаадан, Х. (1986). *Зохист аялгууны толин дахь адилтгал зүйрлэл*. Улаанбаатар.

Галбаатар, Д. (1996). *Эрс эргэлтийн босгон дээр*. Улаанбаатар.

Дашбалбар, О. (1991). *Бурханы мэлмий*. Улаанбаатар.

Лувсанцэрэн, Г. (2001). *Төв үзлийн философийн онолын үндэс*. Философийн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан диссертаци. Улаанбаатар.

Монголын орчин үеийн уран зохиолын товч түүх (1968). Улаанбаатар.

Монголын сонгомол өгүүллэг (2007). Улаанбаатар.

Монголын сонгомол яруу найраг (2007). Улаанбаатар.

Монголын шилдэг өгүүллэгүүд (1971). Улаанбаатар.

Монголын шилдэг яруу найраг (1981). Улаанбаатар.

Сампилдэндэв, Х. (1990) *Яруу найргийн шинэ төлөв*. Улаанбаатар.

Хүрэлбаатар, Л. (1989). *Сонгодог уламжлал монгол яруу найраг*. Улаанбаатар.

Цэнд, Д. (1972). *Монголын орчин үеийн уянгын яруу найраг*. Улаанбаатар.

Энхбаяр, С. (1995). *Ирэх урсгал*. Улаанбаатар.

Энхбаяр, С. (2019). *Утга зохиолын онол*. Улаанбаатар.

Явуухулан, Б. (1990). *Түүвэр зохиол*. Улаанбаатар.

Scovel, Th. (2000). *Psycholinguistics*. Oxford University Press, Oxford.

References

a. *Original text*

- Badarch Puntsagiin (1999). Poetry «Poor». *SOML-65* (Samples of Mongolian literature, hereinafter referred to as SOML). Ulaanbaatar. 198–201 (in Mongolian).
- Banzragch Dashzeveg (2006). «The Man on the Steppe Horse». *Mongolian Classical Poetry*. Ulaanbaatar (in Mongolian).
- Barkhuu Natsag (1995). Poem «Father's steppe». *SOML-8*. Ulaanbaatar. 32–33 (in Mongolian).
- Gavaasuren Ligdensuren (2004). Poem of the song «Dad tied to a dream». *SOML-108*. Ulaanbaatar. 168 (in Mongolian).
- Galsan Tangad (1995). Poem «My father». *SOML-10*. Ulaanbaatar. 269–270 (in Mongolian).
- Gombojav Dorjiin (2002). Poem «My father». *SOML-88*. Ulaanbaatar. 111; poem «Father's cheek». *SOML-88*. Ulaanbaatar. 126 (in Mongolian).
- Davaanyam Danigain (2004). Poem «Father's Wisdom». *SOML-106*. Ulaanbaatar. 425–426 (in Mongolian).
- Dagvadorj Choisureen (2003). Poem «To my father». *SOML-102*. Ulaanbaatar. 71, «Son, I want to love you very much», verse, *SOML-102*. Ulaanbaatar. 76–77 (in Mongolian).
- Dashbalbar Ochirbatyn (2001). Poem «Thoughts», *SOML-74*. Ulaanbaatar. 64–65, Poem «Autumn Wisdom», *SOML-74*. Ulaanbaatar. 78–79, Poem «Mind and Mind», *SOML-74*. Ulaanbaatar. 2001. 244, Poem «Elegy», *SOML-74*. Ulaanbaatar. 2001. 92–97, Poem «The wisdom of victory», *SOML-74*. Ulaanbaatar. 245 (in Mongolian).
- Dashdamba Tserenjamtsyn (2004). Poem «My daughter's birthday». *SOML-107*. Ulaanbaatar. 151 (in Mongolian).
- Dashdoorov Sormuunirshiin (1981). «Father's word» is the best Mongolian poetry. Ulaanbaatar (in Mongolian).
- Dorjpalam Barnan (2002). Poem «Father who did not love anything», *SOML-88*. Ulaanbaatar. 358 (in Mongolian).
- Dorjtseren Navaansharav (2004). Poem «Fathers». *SOML-106*. Ulaanbaatar. 483 (in Mongolian).
- Dulam Sendenjav (2004). Poem «My grandfather that day...». *SOML-93*. Ulaanbaatar. 154 (in Mongolian).
- Dulmaa Shagdar (2000). Poem «My father was a hard worker». *SOML-97*. Ulaanbaatar. 125–127, Poem «Father's hearth». *SOML-79*. Ulaanbaatar. 26 (in Mongolian).
- Jamyaa Dagwyn (1981). «My son» is the best. *Mongolian poetry*. Ulaanbaatar (in Mongolian).
- Lhagvasuren Bavuu (1999). «Poems to leave to grandchildren». *SOML-62*. Ulaanbaatar. 223, Poem «Tomorrow my son will go to the army». -62. Ulaanbaatar. 1999. 104–105, «Read to Your Son». Ulaanbaatar. 1999. 112, Poem «Love a man», -62. Ulaanbaatar. 90–91 (in Mongolian).
- Purevsuren Purevjav (1999). Poem «Father's letter». *SOML-64*. Ulaanbaatar. 59 (in Mongolian).
- Sumyaa Dorjpalamyn (2004). Poem of the song «Father with a homeland». – 107. Ulaanbaatar. 568 (in Mongolian).
- Sundui Bat-Ochirin (2004). Poem «Wise father». *SOML-108*. Ulaanbaatar. 330–334 (in Mongolian).
- Sundui Oyunbadam (2004). Poem «Father and son». *SOML-106*. Ulaanbaatar. 551 (in Mongolian).
- Surenjav Sharav (1998). Poem «My daughter». *SOML-45*. Ulaanbaatar. 277–279, «My dear little girl», verse. 281, «Biography of a tree». 36–37 (in Mongolian).
- Sengee Dashzeveg (1998). Poem «Father's letter». *SOML-42*. Ulaanbaatar. 32 (in Mongolian).

Sereenen Onom (1995). Poem «That's what my true son does». *SOML*-10. Ulaanbaatar. 380–381 (in Mongolian).

Awakening Shagdar (2004). Poem «Dad». *SOML*-108. 358–359 (in Mongolian).

Khangaisaikh Khuren-Alag (2004). Poem «Letter to my father». *SOML*-98. Ulaanbaatar. 153 (in Mongolian).

Khulan Tsoodol (2004). Poem «To my father». *SOML*-108. 388–389 (in Mongolian).

Monk Luvsandamba (2001). Poem «The story of my father as a horseman». *SOML*-76. Ulaanbaatar. 214–233, Poem «My father». *SOML*-76. Ulaanbaatar. 133, «Father's love» poem. *SOML*-76. Ulaanbaatar. 134 (in Mongolian).

Khurelbaatar Byambajav (2002). Poem «Candles offered to my father». *SOML*-84. Ulaanbaatar. 134, «Father's words to go far away». *SOML*-84. Ulaanbaatar. 66, «Following the Father's House». *SOML*-84. Ulaanbaatar. 95–96 (in Mongolian).

Tsoodol Dungutiin (2001). Poem «My children, my children». *SOML*-72. Ulaanbaatar. 79, Poem «Oroi Erentsen». *SOML*-72. Ulaanbaatar. 299–304 (in Mongolian).

Tsedendorj Mishig (1998). Poem «Human footprint». *SOML*-51. Ulaanbaatar. 218–221 (in Mongolian).

Chilaajav Khaidav (2004). Poem of the song «I love my father». *SOML*-108. Ulaanbaatar. 428 (in Mongolian).

Shagdar Zhamtsyn (1981). «Father's love». *The best Mongolian poetry*. Ulaanbaatar (in Mongolian).

Shagdarsuren Danzanyam (2002). Poem «Treasure», *SOML*-88. Ulaanbaatar. 21 (in Mongolian).

Shirchinsuren Mishig (1998). Poem «Daddy and I are three». *SOML*-54. Ulaanbaatar. 162–164, Poem «I will be a father like me in this vast world». *SOML*-54. Ulaanbaatar. 183–184, Poem «Two horses, father, four of us». *SOML*-54. Ulaanbaatar. 165–168, Poem «The sound of a boy's feet». *SOML*-54. Ulaanbaatar. 88–92, «Father's house fire» poem. *SOML*-54. Ulaanbaatar. 175 (in Mongolian).

Erdenebaatar Khoodoo (2006). «Blue Mountains of Uriankhai». Classic Mongolian poetry. Ulaanbaatar (in Mongolian).

Erdenebat Luvsanchultem (2004). «Poems to tell to your son». *SOML*-108. Ulaanbaatar. 279 (in Mongolian).

Erdene-Ochir Arlaan (2004). Poem «When the train moves to Dornogovi». *SOML*-108. Ulaanbaatar. 506 (in Mongolian).

Yavuukhulan Bagzi (1998). Poem «In memory of the father». *SOML*-34. Ulaanbaatar. 90–92, Hymn «Tehiin zogsool». *SOML*-34. Ulaanbaatar. 293–297 (in Mongolian).

b. Research papers

Baigalsaikhan, S. (1995). *Introduction to Literary Studies*. Ulaanbaatar (in Mongolian).

Batkhuuag, P. (2006). *Conversation in poetry*. Ulaanbaatar (in Mongolian).

Byelinskii, V. G. (1947). *Favorite essays*. 28. Moscow (in Russian).

Gaadan, H. (1986). *The analogy in the mirror of proper melody*. Ulaanbaatar (in Mongolian).

Galbaatar, D. (1996). *On the threshold of a sharp turn*. Ulaanbaatar (in Mongolian).

Dashbalbar, O. (1991). *The eyes of God*. Ulaanbaatar (in Mongolian).

Luvsantseren, G. (2001) *Fundamentals of the Theory of Central Philosophy*. Thesis for the degree of Doctor of Philosophy. Ulaanbaatar (in Mongolian).

A Brief History of Modern Mongolian Literature (1968). Ulaanbaatar (in Mongolian).

Mongolian classic story (2007). Ulaanbaatar (in Mongolian).

Mongolian Classical Poetry (2007). Ulaanbaatar (in Mongolian).

- The best Mongolian stories* (1971). Ulaanbaatar (in Mongolian).
The best Mongolian poetry (1981). Ulaanbaatar (in Mongolian).
 Sampildendev, X. (1990). *A new state of poetry*. Ulaanbaatar (in Mongolian).
 Scovel, Th. (2000). *Psycholinguistics*. Oxford University Press, Oxford.
 Khurelbaatar, L., (1989). *Classical tradition of Mongolian poetry*. Ulaanbaatar (in Mongolian).
 Tsend, D. (1972). *Modern Mongolian lyric poetry*. Ulaanbaatar (in Mongolian).
 Enkhbayar, S. (1995). *Incoming flow*. Ulaanbaatar (in Mongolian).
 Enkhbayar, S. (2019). *Literary theory*. Ulaanbaatar (in Mongolian).
 Yavuukhulan, B. (1990). *Collection of literature*. Ulaanbaatar (in Mongolian).